



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

**ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН  
ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН  
СУДАЛСАН ТУХАЙ ТАЙЛАН**

Улаанбаатар хот  
2022 он

**ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН  
ТАНДАН СУДАЛСАН ТУХАЙ ТАЙЛАН**

**ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

Монгол Улсын Их Хурлаас 2006 онд баталсан “Засгийн газрын тусгай сангийн тухай” хуулиар “...үр тариа, төмс, хүнсний ногоо, малын тэжээлийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, тариалан эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэй “Тариалан эрхлэлтийг дэмжих сан”-г байгуулсан.

Тус санг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 16 дугаар тогтоолоор “Мал хамгаалах сан”-тай нэгтгэж одоогийн “Хөдөө аж ахуйг дэмжих сан /ХААДС/-г нэгтгэн байгуулж, зорилт, чиг үүргийг “Хөдөө аж ахуйн салбарт бүх төрлийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх” гэж тодорхойлсон.

Ажлын албаны чиг үүрэг нь төрийн бодлогын хэрэгжилтийг хангах, богино болон урт хугацааны дэмжлэг үзүүлэх, хүнсний болон үрийн буудайн нөөц бүрдүүлэх, гурилын үйлдвэрүүдийг түүхий эдээр хангах бол орон нутгийн салбаруудын чиг үүрэг нь үр тариа цэвэрлэх, стандартад нийцүүлэн буудайг хатаах, технологийн орчинд хадгалах, үр тарианы агуулах түрээслэх, дамжуулах үүрэгтэй.

Сангийн бүтцийн хувьд Улаанбаатар хотод төв байр /бараа хадгалах агуулах, нефтийн агуулахтай/, орон нутагт Угтаал салбар/үр тариа хадгалах 36 мян.тн-ын элеватортой/, Хархорин салбар /үр тариа хадгалах 10 мян.тн-ын элеватортой/, Хөтөл салбар /үр тариа хадгалах 38 мян.тн-ын элеватортой/, Булган салбар/ үр тариа хадгалах 38 мян.тн-ын элеватортой/, Сэлэнгэ салбар /үр тариа хадгалах 28 мян.тн-ын элеватортой/, батлагдсан орон тооны хувьд ажлын албанд 72, орон нутгийн салбаруудад 92, нийт 164 ажилтан ажиллаж байна.

Нийт дүнгээр авч үзвэл, буудай хүлээн авч хадгалах 186 мян.тн-ын элеватортой, бараа хадгалах 1224 м<sup>2</sup> багтаамжтай 38 ширхэг агуулахтай, нефть, түлшний 6,9 мян.м<sup>3</sup>-ын багтаамжтай агуулахтай байна.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 6 дугаар зүйлд санг бүрдүүлэх нийтлэг эх үүсвэрийг улсын төсвийн хөрөнгө, хандив тусламж, тусгай сангийн өөрийн үйл ажиллагаанаас олсон орлого, зээлийн хүүгийн орлого гэсэн 4 эх үүсвэрийг зөвшөөрсөн байдаг. Харин хөрөнгө зарцуулах чиглэлүүдэд усалгаатай тариаланг хөгжүүлэх, услалтын систем байгуулах, сэргээн засварлах, таримал ургамлын үрийн аж ахуйг хөгжүүлэх, хөдөө аж ахуйн техник, технологийн шинэчлэлт хийх, тариалангийн газрыг нөхөн сэргээх, хөрсний үржил шимийг сайжруулах, тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчээс стандартын шаардлага хангасан буудай худалдан авах, худалдах, ХААДС-ийн үндсэн хөрөнгөд засвар үйлчилгээ хийх, бэлчээрийн даацыг тодорхойлох, мал оторлон өвөлжүүлэхтэй холбогдсон судалгаа явуулах, худаг сэргээн засварлах, уст цэг шинээр гаргах, сангийн үндсэн болон өр барагдуулахтай холбогдсон үйл ажиллагаа, зардлыг санхүүжүүлэхэд зарцуулахаар тусгасан байдаг.

Ийнхүү өнөөдөр ХААДС-ийн үйл ажиллагаа нь дээрх хуулиар зохицуулагдаж, өөрийн хөрөнгө, үйл ажиллагааны орлогын эх үүсвэрээр санхүүждэг болон бусад шалтгааны улмаас дараах хүндрэлүүд үүсээд байна. Үүнд:

1. Үйл ажиллагааны хувьд төрийн байгууллагуудаас хэт хамааралтай, зах зээлийн өөрчлөлтөд нийцүүлэн ажиллах, бие даасан үйл ажиллагаа явуулах боломжгүй.
2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг тул Өрийн удирдлага, авлага барагдуулалтын чиглэлээр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх боломж бага.
3. Санхүүгийн хараат байдлаас шалтгаалан үйлдвэрлэл, үйл ажиллагаа, дэмжлэгийн талаар тухайн цаг үеийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн арга хэмжээг түргэн шуурхай авч хэрэгжүүлэх боломжгүй.
4. Эдийн засгийн хувьд үр ашигтай ажиллах, үйл ажиллагаагаа өргөжүүлэх, бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, зээлийн санхүүжилт авах боломж хомс, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх хууль, эрх зүйн боломжгүй зэрэг болно.

Түүнчлэн тус сангийн өнөөгийн байдалд хийсэн үнэлгээг товч дүгнэвэл, байгууллагын хөрөнгийн зохистой харьцаа алдагдсан, авлагын хуримтлал их хэмжээгээр үүсэж, төлбөр барагдуулах чадваргүй болсон, үүссэн өр төлбөрийг гэрээний хугацаанд барагдуулах санхүүгийн чадваргүй болсон, зах зээлийн орчинд өрсөлдөх чадваргүй, өөрчлөлтөд дасан зохицох, уялдан ажиллах боломж хязгаарлагдмал, төрийн хэт их оролцооны нөлөөгөөр өндөр эрсдэлтэй төслүүдийг хэрэгжүүлдэг, тэрхүү төрийн бодлогын хүрээнд хэрэгжүүлсэн нийгмийн ач холбогдол бүхий төслүүдийг хэрэгжүүлэх явцад үүссэн санхүүгийн алдагдлыг сан дангаар хариуцдаг, Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн хүрээнд бизнесийн хувьд ашигтай төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх боломж хязгаарлагдмал зэрэг нь ХААДС-ийн хууль эрх зүйн орчин, өмчлөлийн хэлбэрийг орчин үеийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн өөрчилж, төрийн өмчит ашгийн төлөө хуулийн этгээд байхаар өөрчлөх зайлшгүй шаардлага тулгарч байна.

Ийнхүү өөрчлөлт хийгдсэнээр, дараах давуу тал, боломжууд үүснэ гэж үзэж байна. Үүнд:

- Өмчлөлийн хэлбэр өөрчлөгдснөөр зах зээлийн өөрчлөлтөд нийцүүлэн бизнес, эдийн засаг, санхүүгийн хувьд бие даасан үйл ажиллагаа явуулах боломж бүрдэнэ.
- Үр ашигтай хөшүүргийн бодлогыг хэрэгжүүлэн авлага барагдуулалтыг нэмэгдүүлснээр байгууллагын санхүүгийн чадвар дээшлэнэ /урамшуулал, бусад төрлийн бараа бүтээгдэхүүн, хэрэглэгчийн ангилал гэх мэт/.
- Шаардлагатай засварууд болон худалдан авалтын арга хэмжээг зохион байгуулснаар үйлдвэрлэлийн нөхцөл сайжирч хүнсний аюулгүй байдал, хангамжийг нэмэгдүүлнэ.
- ХАА-н салбарт олгох дэмжлэгийн нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадварыг бий болгох, санхүүгийн эх үүсвэрийн нэр төрөл, тоо хэмжээ нэмэгдэнэ.
- Зах зээлийн бодит эрэлт, хэрэгцээнд тулгуурласан дэмжлэгийн бодлогыг харилцан үр ашигтай байхаар хэрэгжүүлнэ.
- Хөрөнгийн ашиглалт, зарцуулалт сайжрах, хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлнэ.

- Олон улсын ижил төстэй үйл ажиллагаа бүхий байгууллагуудтай хамтран ажиллах, дэвшилтэт техник, технологи, арга барилыг үйлдвэрлэлд нэвтрүүлнэ.
- Байгууллагын санхүүгийн чадвар нэмэгдснээр улсын төсөвт учирч буй өрийн дарамтыг бууруулах эерэг үр дүн авчирна.

Шинээр байгуулагдах “Хөдөө аж ахуйн корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь хүнсний болон үрийн улаанбуудайн нөөцийг бүрдүүлэх чиг үүрэг хэвээр уламжлагдан үлдэх бөгөөд үйл ажиллагаа өргөжин, санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, өмнө нь улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж байсан олон ажил, үйлчилгээг аж ахуйн тооцоо, ашигт ажиллагаанаас орсон орлогоор санхүүжүүлнэ. Тухайлбал, таримал ургамлын үр, суулгац, сортын үрийн үржүүлэг, ургамал хамгааллын бодис, бордоо, шатахууны импортын худалдаа, хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмжийн диллерийн болон түрээсийн үйлчилгээ, засвар, сэлбэг хэрэгслийн худалдаа, хөдөө аж ахуйн зөвлөх, нэвтрүүлэх үйлчилгээ зэргийг дурдаж болно.

Ийнхүү үйл ажиллагаагаа өргөжүүлэн ажиллахад дараах зарчмуудыг баримтлах болно. Үүнд:

- Дотоодын зах зээлд тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөллийг хамгийн бага байлгах;
- Ашигт ажиллагааны түвшинг зохистой хэмжээнд байлгаж, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд эергээр нөлөөлөхүйц хэмжээнд байлгах;
- Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийг үнийн дарамтаас хамгаалах;
- Бодит эрэлт хэрэгцээнд тулгуурласан бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгох;
- Шударга, хүртээмжтэй хуваарилалтын тогтолцоог бүрдүүлэх;
- Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн технологитой уялдсан тасралтгүй нийлүүлэлтийн бодлого хэрэгжүүлэх;
- Дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжих зэрэг болно.

“Хөдөө аж ахуйн корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулагдсанаар зах зээлийн өөрчлөлтөд нийцүүлэн бизнес, эдийн засаг, санхүүгийн хувьд бие даасан үйл ажиллагаа явуулах шийдвэр гаргах хууль эрхзүйн үндэс бүрдэж, хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр бүрдүүлэх илүү боломжууд нээгдэнэ. Улмаар хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн хэрэгцээт бараа, үйлчилгээг хямд үнээр санал болгож, тэдний үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэн, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах замаар нийт Монгол улсын иргэдийн хүнсний хангамж, аюулгүй байдлын баталгааг хангах, тогтворжуулах нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна.

## НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

### 1.1. Асуудлыг тодорхойлж, асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоосон байдал

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 6 дугаар зүйлд санг бүрдүүлэх нийтлэг эх үүсвэрийг улсын төсвийн хөрөнгө, хандив тусламж, тусгай сангийн өөрийн үйл ажиллагаанаас олсон орлого, зээлийн хүүгийн орлого гэсэн 4 эх үүсвэрийг зөвшөөрсөн байдаг. Харин хөрөнгө зарцуулах чиглэлүүдэд усалгаатай тариаланг хөгжүүлэх, услалтын систем байгуулах, сэргээн засварлах, таримал ургамлын үрийн аж ахуйг хөгжүүлэх, хөдөө аж ахуйн техник, технологийн шинэчлэлт хийх, тариалангийн газрыг нөхөн сэргээх, хөрсний үржил шимийг сайжруулах, тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчээс стандартын шаардлага хангасан буудай худалдан авах, худалдах, ХААДС-ийн үндсэн хөрөнгөд засвар үйлчилгээ хийх, бэлчээрийн даацыг тодорхойлох, мал оторлон өвөлжүүлэхтэй холбогдсон судалгаа явуулах, худаг сэргээн засварлах, уст цэг шинээр гаргах, сангийн үндсэн болон өр барагдуулахтай холбогдсон үйл ажиллагаа, зардлыг санхүүжүүлэхэд зарцуулахаар тусгасан байдаг.

Иймд хуулийн хэрэгцээ, шаардлагыг тогтоохдоо Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ыг баримтлан гүйцэтгэв.

### 1.2. Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээд

Дээр тодорхойлсон цар хүрээтэй холбоотойгоор дараах нийгмийн бүлэг, бусад этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж байна гэж үзлээ.

	Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг	Нөлөөлж буй хэлбэр
1.	Хэрэглэгчид	Хүнсний аюулгүй байдал, хангамж нэмэгдэнэ.
2.	Үйлдвэрлэгчид	Зах зээлийн эрэлт, хэрэгцээнд тулгуурласан дэмжлэгийг олон нэр төрлөөр, хүртээмжтэй байдлаар хүргэнэ.
3.	Засгийн газар	Байгууллагын санхүүгийн чадвар нэмэгдсэнээр улсын төсөвт учирч буй өрийн дарамт, ачааллыг бууруулна.

### 1.3. Асуудал үүссэн шалтгаан, нөхцөл

Хөдөө аж ахуйг дэмжих сангийн өнөөгийн байдалд хийсэн үнэлгээг товч дүгнэвэл, байгууллагын хөрөнгийн зохистой харьцаа алдагдсан, авлагын хуримтлал их хэмжээгээр үүсэж, төлбөр барагдуулах чадваргүй болсон, үүссэн өр төлбөрийг гэрээний хугацаанд барагдуулах санхүүгийн чадваргүй болсон, зах зээлийн орчинд өрсөлдөх чадваргүй, өөрчлөлтөд дасан зохицох, уялдан ажиллах боломж хязгаарлагдмал, төрийн хэт их оролцооны нөлөөгөөр өндөр эрсдэлтэй төслүүдийг хэрэгжүүлдэг, тэрхүү төрийн бодлогын хүрээнд хэрэгжүүлсэн нийгмийн ач холбогдол бүхий төслүүдийг хэрэгжүүлэх явцад үүссэн санхүүгийн алдагдлыг сан дангаар хариуцдаг, Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн хүрээнд бизнесийн хувьд ашигтай төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх боломж хязгаарлагдмал зэрэг нь

ХААДС-ийн хууль эрх зүйн орчин, өмчлөлийн хэлбэрийг зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн өөрчилж, төрийн өмчит ашгийн төлөө хуулийн этгээд байхаар өөрчлөх зайлшгүй шаардлага тулгарч байна.

### ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Ерөнхий зорилго:

“Хөдөө аж ахуйн корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийг байгуулснаар хөдөө аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдийн зах зээлийн бодит эрэлт, хэрэгцээнд тулгуурласан бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, хүртээмжтэй хуваарилалтын тогтолцоог бүрдүүлэх, үйлдвэрлэлийн технологитой уялдсан тасралтгүй нийлүүлэлтийг хангах, дотоодын үйлдвэрлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх боломж бүрдэнэ.

Тусгай зорилго:

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 8.3 дахь зорилтод “Хөдөө аж ахуйг байгальд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадвартай, нийгмийн хөгжлийн чиг хандлага, хэрэгцээ, шаардлагад нийцсэн, хариуцлагатай, бүтээмж өндөр, тогтвортой үйлдвэрлэлтэй эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ” гэж заасан.

### ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЭРЭГ БОЛОН СӨРӨГ ТАЛЫН ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, Аргачлалын 5-д заасны дагуу зорилгод хүрэх байдал буюу зорилгыг хангаж чадах эсэх, зардал, үр өгөөжийн харьцаа буюу хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үзүүлэх эерэг өөрчлөлтийг харьцуулан судалж дараах дүгнэлтийг гаргалаа.

Зохицуулалтын хувилбар	Харьцуулалт		Үр дүн
	Эерэг	Сөрөг	
1.“тэг” хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах	Асуудлын зорилго хангагдахгүй учраас тэг зохицуулалт манай тохиолдолд шаардлагагүй.	Асуудал байсаар байна. Зорилго хангагдахгүй. Бие даасан үйл ажиллагаа явуулах боломжгүй хэвээр байна.	Үр ашиг байхгүй.
2.Хэвлэл, мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх;	Төрийн өмчит хуулийн этгээд байгуулах асуудал энэ зохицуулалтын хувилбарын хувьд оновчгүй буюу шаардлагагүй.	ХААДС-д өр төлбөртэй иргэн, аж ахуйн нэгжүүд зээлийн төлбөрөө хүлээлгэх магадлалтай тул оновчгүй шийдэл болно.	Үр дүн багатай.
3.Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх;	Төрөөс зохицуулалт хийж, газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжсээр ирсэн.	ХААДС-ийн үйл ажиллагаа төрийн байгууллагуудаас хэт хамааралтай байгаагаас зах зээлийн өөрчлөлтөд нийцүүлэн ажиллах боломжгүй.	Үр ашиггүй.

4.Төрөөс санхүүгийн интервенц хийх	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг урамшуулал, татаасын бодлогоор дэмжсэнээр дотоодын үйлдвэрлэл нэмэгдэх боломжтой.	Монгол улсын эдийн засгийн нөхцөл байдал хүнд байгаа энэ үед санхүүжилт байхгүй. Нөгөөтэйгүүр энэ нь зөвхөн нэг удаагийн зохицуулалт болох ба бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоо нэмэгдэх, тариаланчид бэлэнчлэх сэтгэлгээтэй болох талтай.	Зардал өндөртэй, үр дүн багатай.
5.Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх;		энэ зохицуулалтын хувилбарын хувьд төрийн бус байгууллага оролцох боломжгүй. Зардал өндөртэй.	Үр ашиггүй.
6.Захиргааны шийдвэр гаргах	-	Эрх олгосон заалт байхгүй учраас захиргааны ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.3-т заасан шийдвэр гаргаж, зохицуулах боломжгүй.	Үр ашиггүй.
7.Хууль тогтоомжийн төсөл боловсруулах.	Өмчлөлийн хэлбэр өөрчлөгдсөнөөр зах зээлийн өөрчлөлтөд нийцүүлэн бизнес, эдийн засаг, санхүүгийн бие даасан үйл ажиллагаа явуулах боломж бүрдэнэ.		Үр дүнтэй гэж үзэж байна.

“Хөдөө аж ахуйн корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулагдсанаар зах зээлийн өөрчлөлтөд нийцүүлэн бизнес, эдийн засаг, санхүүгийн хувьд бие даасан үйл ажиллагаа явуулах шийдвэр гаргах хууль эрхзүйн үндэс бүрдэж, хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр бүрдүүлэх илүү боломжууд нээгдэнэ. Улмаар хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн хэрэгцээт бараа, үйлчилгээг хямд үнээр санал болгож, тэдний үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэн, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах замаар нийт Монгол улсын иргэдийн хүнсний хангамж, аюулгүй байдлын баталгааг хангах, тогтворжуулах нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна.

#### **ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ**

Аргачлалын 6-д заасны дагуу өмнөх үе шатанд сонгон авсан хуулийн төсөл боловсруулах хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

Жич: Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг Хавсралт 1-ын 1, 2, 3, 4 дүгээр хүснэгтээс үзнэ үү.

#### **4.1. “Хүний эрхэд үзүүлэх нөлөө”**

Уг хууль нь хүний эрхийн зөрчил, хүний эрхийг хязгаарласан, мөн жендерийн тэгш байдлыг зөрчих зохицуулалт агуулаагүй, тэгш хандлагатай. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд зах зээлийн бодит эрэлт, хэрэгцээнд тулгуурласан дэмжлэгийн бодлогыг харилцан үр ашигтай байхаар хэрэгжүүлж, Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний эрх, эрх чөлөөг хангахад эерэг нөлөө үзүүлнэ.

#### **4.2. “Эдийн засагт үзүүлэх нөлөө”**

Уг хууль батлагдсанаар улсын төсөвт учирч буй өрийн дарамтыг бууруулах, хөрөнгийн ашиглалт, зарцуулалт сайжрах, хөдөө аж ахуйн салбарт олгох дэмжлэгийн хүртээмж нэмэгдэж, санхүүгийн эх үүсвэрийн нэр төрөл, тоо хэмжээ нэмэгдэх эерэг үр дүн авчирна.

#### **4.3. “Нийгэмд үзүүлэх нөлөө”**

Нийгэмд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй. Харин эрх зүйн орчныг бүрдүүлснээр, шаардлагатай засварууд болон худалдан авалтын арга хэмжээг зохион байгуулснаар үйлдвэрлэлийн нөхцөл сайжирч хүнсний аюулгүй байдал, хангамжийг нэмэгдүүлэх тул нийгэмд эерэг нөлөөтэй.

#### **4.4. “Байгаль орчинд үзүүлэх нөлөө”**

Байгаль орчинд ямар нэгэн шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй.

#### **4.5. “Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх.”**

Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээ бусад хуультай аливаа зөрчил үүсгэхгүй.

### **ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ**

Аргачлалын 7-д зааснаар хувилбарын эерэг болон сөрөг талуудыг

- Зорилгод хүрэх байдал;
- Зардал, үр өгөөжийн харьцаа;
- Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө;
- Хууль тогтоомжтой нийцэж буй эсэх;
- Гарч болох сөрөг үр дагавар, түүнийг арилгах хувилбар байгаа эсэх гэсэн шалгуураар дахин нягтлан үзэж дараах дүгнэлтийг хийлээ.

Монгол Улсын Үндсэн хууль, Монгол улсын Олон улсын гэрээ конвенцийн үзэл баримтлалд заасан хүний эрүүл мэндээ хамгаалуулах эрх, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх болон эдийн засгийн эрх, эрх чөлөөг хангах замаар иргэдийн зохистой, баталгаатай хоол хүнсээр хангагдах боломжийг дотоодын үйлдвэрлэлээр бүрдүүлэх ажлын хүрээнд дурдсан асуудлыг хуулийн төсөл боловсруулах аргаар шийдвэрлэх нь оновчтой хувилбар гэж дүгнэлээ.

### **ЗУРГАА. ТУХАЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**

Хөдөө аж ахуйн салбар өндөр хөгжсөн бусад улс орнуудад газар тариалангийн салбарыг стратегийн хувьд ач холбогдолтойгоос гадна эдийн засгийн тулгуур салбар гэж үзэн татвар болон татаасын бодлогоор дэмждэг байна.

Тухайлбал, Холбооны Бүгд Найрамдах Герман улс техник үйлдвэрлэгч, газар тариалангийн техникийн экспортоороо дэлхийд тэргүүлэгч улс атлаа хөрс боловсруулалтад улсаас татаас өгдөг. Харин Бүгд Найрамдах Солонгос улс бордоо, ургамал хамгааллын бодис, тэжээл, хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж, хүлэмжийн тоног төхөөрөмжийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлдөг, хөдөө аж ахуйд ашиглагдах шатахууныг бүх төрлийн татвараас чөлөөлдөг байна.

АНУ, ОХУ 1930 оноос, Япон, БНСУ 1940 оны сүүлч, 1950 оны эхнээс хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэхэд гол анхаарлаа нэмэгдүүлж нэгдмэл төлөвлөлт, бодлого хэрэгжүүлж үнэ тарифын зохицуулалт хийх, татвар даатгалын тогтолцоог уян хатан болгох зэрэг бодлого, хууль эрх зүйн зохицуулалтыг маш амжилттай хэрэгжүүлсэн байна.

### ДОЛОО.ЗӨВЛӨМЖ

Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлаад манай асуудлыг зохицуулах хувилбарыг томъёолсон болно.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсэгт “5.3.19” гэснийг хасах, мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.19 дэх заалт, 21 дүгээр зүйлийг тус тус хүчингүй болгох, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах шаардлагатай.

Хууль тогтоомжийн төсөл боловсруулах зохицуулалтын хувилбар нь одоогийн нөхцөлд дэвшүүлсэн зорилгыг хангах хамгийн боломжит хувилбар бөгөөд Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, хүний эрх, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө байхгүй болно.

Уг хуулийн төсөл батлагдснаар зах зээлийн өөрчлөлтөд нийцүүлэн бизнес, эдийн засаг, санхүүгийн хувьд бие даасан үйл ажиллагаа явуулах шийдвэр гаргах хууль эрх зүйн үндэс бүрдэж, хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр бүрдүүлэх илүү боломжууд нээгдэнэ. Улмаар хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн хэрэгцээт бараа, үйлчилгээг хямд үнээр санал болгож, тэдний үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэн, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах замаар нийт Монгол улсын иргэдийн хүнсний хангамж, аюулгүй байдлын баталгааг хангах, тогтворжуулах нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна.

### Хавсралт-1 Хувилбарын хүний эрх, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх нөлөөг үнэлсэн байдал

#### 1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх Үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж	<b>1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх</b>		
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	<b>Үгүй</b> Хүний эрхийн зөрчлийг агуулаагүй
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	<b>Үгүй</b> Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулаагүй, тэгш хандалгатай

	1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Олон нийтийн эрхийг аливаа хэлбэрээр зөрчөөгүй
	1.2.Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Үгүй	Үйлдвэрлэгчдийн санал хүсэлтийг авч, бодит нөхцөл байдлыг судалсан.
	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Эрх, хууль ёсны ашиг сонирхолд нөлөөлөх эсэхийг тогтоож, үр нөлөөг тооцсон.
	1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Үгүй	Хүн бүрт олгогдсон тэгш боломж, тэгш эрхийн баталгаа бүрдэнэ
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмийн талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Хүн бүр тэгш эрхтэй байх нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд чиглүүлнэ.
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй	Зохицуулалт байхгүй
2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн хязгаарлалт хийгдэхгүй.
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	Үгүй	-----“-----
3.Эрх агуулагч	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	-----“-----
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	-----“-----
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Үгүй	-----“-----
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх	Тийм	Үгүй	Энэ төрлийн зохицуулалт байх шаардлагагүй.

	(хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)			
<b>4. Үүрэг хүлээгч</b>	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	<b>Тийм</b>	Үгүй	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигч төр байна.
<b>5. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх</b>	5.1. Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	<b>Тийм</b>	Үгүй	Жендэрийн тэгш байдлыг зөрчих зохицуулалт байхгүй.
	5.2. Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	<b>Тийм</b>	Үгүй	Хөдөлмөрийн болон Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуульд заасан үйлчлэл хамаарна

2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
<b>1. Дэлхийн зах зээл өрсөлдөх чадвар</b>	1.1. Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	<b>Тийм</b>	<b>Үгүй</b>	-----“-----
	1.2. Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	<b>Тийм</b>	<b>Үгүй</b>	-----“-----
	1.3. Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	<b>Тийм</b>	<b>Үгүй</b>	-----“-----
<b>2. Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал</b>	2.1. Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	<b>Тийм</b>	<b>Үгүй</b>	-----“-----
	2.2. Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	<b>Тийм</b>	<b>Үгүй</b>	-----“-----
	2.3. Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	<b>Тийм</b>	<b>Үгүй</b>	-----“-----
	2.4. Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	<b>Тийм</b>	<b>Үгүй</b>	-----“-----
<b>3. Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал</b>	3.1. Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	<b>Тийм</b>	<b>Үгүй</b>	-----“-----
	3.2. Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	<b>Тийм</b>	<b>Үгүй</b>	-----“-----
	3.3. Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	<b>Тийм</b>	<b>Үгүй</b>	-----“-----

	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	Үгүй	-----“-----
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	Үгүй	-----“-----
<b>4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал</b>	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	Үгүй	-----“-----
<b>5.Өмчлөх эрх</b>	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	Үгүй	-----“-----
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	-----“-----
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	-----“-----
<b>6.Инноваци болон судалгаа шинжилгээ</b>	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Үгүй	-----“-----
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Үгүй	-----“-----
<b>7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв</b>	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	-----“-----
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Үгүй	-----“-----
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-----“-----
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	-----“-----
<b>8.Тодорхой бүс нутаг, салбарууд</b>	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй	-----“-----
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	-----“-----

	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	-----“-----
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	-----“-----
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	Үгүй	-----“-----
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Үгүй	-----“-----
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	-----“-----
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Үгүй	-----“-----
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	-----“-----
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	-----“-----

3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	Үгүй	Аж ахуйн нэгжийн тоо нэмэгдэх, шинээр ажлын байр бий болох магадлалтай.
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Тийм	Үгүй	-----“-----
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	ХАА-н үйлдвэрлэгчдэд эерэгээр нөлөөлнө.
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Шууд бусаар нөлөөлөх боломжтой.
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Сүүлийн үеийн шинэ тоног төхөөрөмж нэмэгдэнэ. Энэ тохиолдолд шууд бусаар нөлөөлнө.
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Сүүлийн үеийн шинэ, дэвшилтэт тоног төхөөрөмж нэмэгдэнэ. Энэ тохиолдолд шууд бусаар нөлөөлнө.
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-----“-----

	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Үгүй	-----“-----
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Сүүлийн үеийн шинэ, дэвшилтэт тоног төхөөрөмж нэмэгдэнэ.
<b>3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал</b>	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	-----“-----
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	Үгүй	Тэгш хандана.
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-----“-----
<b>4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун</b>	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-----“-----
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-----“-----
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-----“-----
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-----“-----
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-----“-----
<b>5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал</b>	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-----“-----
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	-----“-----
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-----“-----
<b>6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем</b>	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-----“-----
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-----“-----

	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	-----“-----
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	-----“-----
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-----“-----
	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-----“-----
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-----“-----
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	-----“-----
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	-----“-----
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	-----“-----
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-----“-----
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-----“-----

1. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	-----“-----
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	Үгүй	-----“-----
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	-----“-----
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	-----“-----
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	-----“-----
3.Ан амьтан,	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	Үгүй	

ургамлыг хамгаалах	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-----“-----
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-----“-----
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-----“-----
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-----“-----
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	-----“-----
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-----“-----
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	-----“-----
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	-----“-----
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Үгүй	-----“-----
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	-----“-----
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	-----“-----
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	Үгүй	-----“-----
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	-----“-----